

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017-04-05**

Тендер шалгаруулалтын нэр: **Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: ДУ ОНӨГ/201700004

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **аймгийн Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажлыг** гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (**хүсвэл нэмэлт хувийг**) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **100,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна. Тендерийн баримт бичгийн үнийг 100080051006 тоот дансанд тушаана.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2015, 2016 оны борлуулалтын орлогын дундаж нь 40 сая төгрөгөөс **байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 30 сая төгрөгөөс **багагүй байх**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2015, 2016 жил**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Нэг удаад хийсэн ажил нь 50 сая төгрөгөөс **багагүй байх**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай : Барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд энэ нь “Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт” хийх заалттай байна. Эсвэл Эрчим хүчний яамнаас олгосон хамгийн багадаа 0,4-10кв ЦДШ, дэд станцын засвар угсралт, түүний туршил, тохируулгын ажил гүйцэтгэх заалттай байна.

Тендерийн хамт 910,442 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 05-р сарын 04** ний өдрийн **12** цаг **00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 05-р сарын 04** - ний өдрийн, **12** цаг **55** минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дундговь аймаг, Орон нутгийн өмчийн газар
Утас: 70593399, 88900015